

**“ЯДУУ МАЛЧИН ӨРХҮҮДЭД УСТ ЦЭГ БА НЭВТРҮҮЛЭХ ТӨВ БАЙГУУЛАХ”
ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл	
1	Төслийн нэр		“Ядуу малчин өрхүүдэд зориулсан уст цэг ба нэвтрүүлэх төв байгуулах” (JFPR-9124-MON) төсөл	
2	Санхүүжүүлэгч байгууллага		АХБ, Ядуурлыг бууруулах Японы сан	
3	Хэрэгжүүлэгч байгууллага		ХХААХҮЯ	
4	Хамрах хүрээ		Өвөрхангай аймгийн 10 сумдын малчдын бүлгүүд, ХАА-н нэвтрүүлэх төв	
5	Хэрэгжүүлэх хугацаа		2008.10.15-2011.10.14	
6	Төслийн зорилго		<ul style="list-style-type: none"> Бэлчээрт шинэ уст цэг байгуулж, түүнийг дагалдах усны менежментийн дэ бүтцийг бий болгох. Өвөрхангай аймагт ашиглагдаагүй байгаа бэлчээрийн ашиглалтыг нэмэгдүүлэх. Орон нутагт уст цэг ба түүний орчмын бэлчээрийг ашиглах хүчирхэг бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх. Сумдын түвшинд хөдөө аж ахуй, нийгмийн үйлчилгээг хүргэх чадавхийг бий болгох зорилгоор нэг цэгийн төв байгуулах. 	
7	Хүлээгдэж буй үр дүн		<p>1.Ашиглалт багатай бэлчээрт уст цэгийг шинээр гаргана, сэргээнэ.</p> <p>2.Уст цэг, бэлчээрийн ашиглалтыг төлөвлөх, удирдах, хэрэгжүүлэх талаархи малчдын бүлгийн чадавхи нэмэгдэнэ.</p> <p>3.Бэлчээрийн удирдлага, мал аж ахуйн үйлдвэрлэл, амьжиргааны хувилбарт эх үүсвэр, үйлчилгээний чиглэлээр малчдад болон малчдын бүлгүүдэд үзүүлэх нэвтрүүлэх үйлчилгээ сайжирна.</p>	
8	Зардал (ам.доллар)	Төсөв (тайлант оны)		
		Гүйцэтгэл (тайлант оны)	223775\$ –Ядуурлыг бууруулах Японы сангаас-175,069\$ -МУЗГ-аас- 10,669 \$ -“VSO” ОУ-ын байгууллагаас-38,041 \$	
			зардлууд	Үнэ/ам.\$/
			Цалин	87,615
			Ашиглалтын зардал	24,843
		Сургалт, зөвлөгөөн	38,266	
		Дотоод зөвлөхийн зардал	49,095	
		Эд хогшил,компьютер	27,122	
		Гадаад зөвлөхийн зардал	38,041	
	Санхүүгийн талаар:		Тайлант хугацаанд:Ядуурлыг бууруулах Японы сангаас нийт 175,069 ам.\$-тай тэнцэх зардлыг санхүүжүүлсэн нь АХБ-ны санхүүжилтын төсвийн 9%-тай тэнцэж байна. Гэрээнд хүлээсэн үүргийн дагуу МУЗГ-аас төслийн ажил гүйлгээг НӨАТ-аас чөлөөлөх, ТҮН ба ТХН-ийг албан тасалгаа, оффиссын тавилга, компьютер зэрэг эд хогшлоор хангах хэлбэрээр бүгд 10,669 ам.\$-ыг зарцуулжээ. Төслийн хэрэгжилтийн зөвлөх VSO-Монгол байгууллагаас ОУ-ын сайн дурын зөвлөхийг 2009 оны 3 сарын 20-ноос 8 сарын 11-нийг хүртэлх хугацаанд ТХН дээр ажиллуулахад өөрийн эх үүсвэрээс	

			38,041 ам\$-ыг зарцуулсан. Мөн төслийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалт, зөвлөх ажиллуулахын өмнөх сургалт зэрэг ажилд 38,040 ам\$-ыг зарцуулсан байна.			
9	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	зорилтууд	I	II	III	IV
		Биелэлт % 72,0 %	75.0	75.0	70.0	68.0
10	Хөтөлбөрийн хэрэгжилт		Төслийн зорилтыг хангах хүрээнд 2009 онд нийт 137 ажил төлөвлөгдсөнөөс 61%-ийг сайн биелэлттэй, 27%-нь үргэлжилж буй ажлууд, 1% нь огт хэрэгжээгүй, 11% нь хойшлогдсон ажлууд эзэдж байна. Тасарсан 2 ажилд төслөөс зорилтот 10 сумын ХААНТ-д нийлүүлэх тоног төхөөрөмжийн тендерийн баримт бичиг боловсруулах, төслийн тусгай дансны нөхөн дүүргэлт орж байна. Тендерийн баримт бичгийг боловсруулах ажил сумдаас зарим нэг мэдээллийг нягтлах шаардлага байсан тул хэрэгжээгүй. Шалтгааныг авч үзвэл:			
№	Хойшлогдсон ажлууд		Шалтгаан			
1	АХБ-ны зөвлөхийг ажиллуулах		Зөвлөхийг ажиллуулах шаардлагагүй гэж үзсэн			
2	Уст цэг сэргээн засварлах		Шинээр барих сэргээн засварлах уст цэгийн судалгаанд хүчээ төвлөрүүлэн ажилласнаас ондоо багтаагүй.			
3	Байгаль орчны үнэлгээний аргачлал боловсруулах		Ажлын ачааллаас шалтгаалан АХБ-тай 2010 он 1 дүгээр сард гүйцэтгэхээр тохирсон.			
4	Худгийн ашиглалтанд хяналт тавих сургалт		Худаг барих үед малчдын бүлгээс хяналт тавих сургалтыг нэн түрүүнд зохион байгуулах шаардлагатай болсон.			
5	Бэлчээрийн малчдын эрх үүргийг сурталчлах		Сургалтыг зохион байгуулах цаг хугацааны боломжгүй байдлаас шалтгаан бэлчээрийн төлөвлөлтийн сургалтанд энэ талаар тусгаж оруулсан.			
6	Төслийн үйл ажиллагааг хянах үнэлэх төлөвлөх зөвлөгөөн		Сумдын засаг дарга нарыг болон аймгийн удирдлагыг бүрэн хамруулах шаардлагатай тул 2010 он 1 дүгээр сарын 6-ны өдрийг хүртэл хойшлуулсан			
7	Газар тариалан-мал аж ахуй хосолсон аж ахуйд дадлага зохион байгуулах		Энэ чиглэлээр сонирхсон малчид 2009 онд гараагүй.			
8	Малчдын бүлгүүдэд бизнес төлөвлөгөө боловсруулахад нь туслах		Гахайн ханиаднаас шалтгаалан бизнес төлөвлөгөөний арга зүйн сургалтыг 2009 оны 12 дугаар сарын 21 хүртэл 17 хоног зохион байгуулсан тул энэ онд багтсангүй.			
9	Ирж буй оны төлөвлөгөө хэлэлцэх уулзалт зохион байгуулах		Үүнийг төслийн үйл ажиллагааны хянах үнэлэх төлөвлөх зөвлөгөөнтэй хамтруулан хийхээр шийдвэрлэсэн.			
11	Үр дүн:1. Өвөрхангай аймгийн 10 суманд нийт 60 худгийг шинээр гаргах буюу сэргээн засварлаж, 60 Малчдын бүлэг буюу 900 малчин өрхүүд 168000 га орчим бэлчээрийг ашиглана.		Үр дүн 1. Төслөөс усны талаар баримтлах стратеги боловсруулсан. Бэлчээрийн төлөв байдал, гидрогеологийн хээрийн судалгааг геоморфологи, геологи-тектоник, гидрогеологи, геоботаник шинж тэмдэг болон биолокацийн аргыг хослуулан 66 Малчдын бүлэг дээр гүйцэтгэж шинээр байгуулах боломжтой-29, сэргээн засварлах-16, булгийн эхийг хамгаалах -2 уст цэгийг тус тус илрүүлжээ. 2009 онд Бүрд сумын “Уст хайрхан” МБүлэгт-1, Есөн зүйл сумын “Сарын гол”, “Баянхангай” МБүлэгт- 2, нийт-3 худаг шинээр гаргав. Бэлчээрийн төлөвлөгөө боловсруулах сургалтыг 60 МБ, төслийн сумдын газрын даамал, нэвтрүүлэх төвийн ажилтнуудыг хамруулсан. Сумын Засаг дарга болон МБ-ийн хооронд байгуулах			

		бэлчээр ашиглалтын гэрээг боловсруулжээ. Хэрэгжилт -75%
	Үр дүн:2. Малчдын бүлгүүд орон нутгийн захиргаатай гэрээний үндсэн дээр уст цэг, бэлчээрийг ашиглана. Уст цэгийн 10-аас доошгүй хувийг МБ дундаасаа гаргана.	Төсөлтэй хамтран ажиллахаар саналаа ирүүлсэн 190 МБ-ээс 66МБ-ийг судалж, 39 МБ-тэй ус бэлчээрийн чиглэлээр хамтран ажиллах 3 талт гэрээг байгуулсан. Бэлчээрийн чиглэлээр дагнан ажиллах 14 Малчдын бүлгийг тогтоов. “Нутгийн оролцоотой МБ-ийг сонгон шалгаруулах зөвлөгөөн”-ийг 10 суманд 22 удаа зохион байгуулжээ. МБ-ийн 75% нь үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон, 63% нь бүлгийн дүрмээ баталсан, 38% нь дундын сан байгуулсан байна. Есөн зүйл сумын Баянхангай МБ төлбөл зохих оролцооныхоо 94%-ийг төлсөн. Энэ нь төсөлтэй хамтран ажиллаж буй бүлгүүд харьцангуй богино хугацааны дотор төлөвшиж, хөгжиж байгаагийн илрэл юм. Хэрэгжилт 75%
	Үр дүн:3. Сумын хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвүүд, 10-аас доошгүй нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлдэг бие даасан агентуудын чадавхи бий болно.	Төслөөс ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний талаар баримтлах стратегийг боловсруулсан. Сумын ХААНТөвд нийлүүлэх тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан. Малчдын сургалтын хэрэгцээг тодорхойлжээ. Хэрэгжилт-70%
	Үр дүн:4. Бэлчээрийн менежмент, МАА-н үйлдвэрлэл, амьжиргааны хувилбарт эх үүсвэрийг дэмжсэн нэвтрүүлэх үйлчилгээг 10 сумдын 100 ядуу МБ-үүдэд хүргэж, төслийн хугацаанд тэдгээрийн орлогыг 15-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ.	МБ-ийг удирдлага, зохион байгуулалт, бэлчээрийн менежментийн үндэс, уст цэг тогтоох, түүнийг шинээр бий болгоход орон нутгийн оролцоо, малчдын бизнесийн үндсэн ойлголт, ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээ, бэлчээрийн төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө гэсэн сэдвүүдээр аймгийн түвшинд-5, сумын түвшинд-36, малчдын хотонд 29 удаа сургалт, зөвлөгөөнүүд, танилцах аялал, дадлагыг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 1500 гаруй хүмүүсийг хамруулжээ. Сумдад хөгжүүлэх бололцоотой бизнесийн чиглэлүүдийн судалгааг хийсэн. Хэрэгжилт-68%
12	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Төсөлтэй хамтран ажиллахаар сонирхлоо илэрхийлсэн 190 гаруй МБ-ээс тодорхой шалгуур үзүүлэлтийг үндэслэн 66 МБ дээр бэлчээрийн төлөв байдал, гидрогеологийн хээрийн судалгааг хийж, ус бэлчээрийн талаар ажиллах 39 МБ, зөвхөн бэлчээрийн чиглэлээр ажиллах 14 МБ байгааг тогтоож Өвөрхангай аймаг дахь Төслийн зөвлөх хорооны даргад танилцуулж баталгаажуулан, улмаар ХХААХҮЯ-ыг төлөөлж ТУХ-ны дарга, орон нутгийг төлөөлж Сумын засаг дарга, бүлгийг төлөөлж бүлгийн ахлагч нарын хооронд гурван талт хамтын ажиллагааны гэрээг байгуулжээ. Үлдсэн бүлгүүдийг 2010 онд судалж шалгаруулна. МБ байгуулж, бэхжүүлэх, ахлагчийн манлайлал сургалтыг аймаг, сум, бүлгийн түвшинд зохион байгуулсны үр дүнд малчдын ихэнх бүлэг (75%) үйл ажиллагааны чиглэлээ хамт олноороо хэлэлцэж, тодорхойлсон, 62.5% нь бүлгийн дүрмээ баталсан, 37.5% бүлгийн дундын сан байгуулсан байна. Энэ нь төсөлтэй хамтран ажиллаж буй бүлгүүд харьцангуй богино хугацааны дотор төлөвшиж, хөгжиж байгаагийн илрэл юм. Төслөөс усны менежментийн стратеги, бэлчээрийн менежментийн талаархи төслийн стратегийг тус тус боловсруулсан. Малчин өрхийн МАА-н бус орлогыг нэмэгдүүлэх боломжийг судалж байна. АХБ-ны зөвлөмжийг

		<p>үндэслэн уст цэг шинээр байгуулах талаар ХХААХҮЯ-наас Тэнхлэг-Ус ХК-тай байгуулсан гэрээнд 2009 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр өөрчлөлт оруулснаар тус компани гэрээний зөвхөн 2-р багцын хүрээнд Өвөрхангай аймгийн Бүрд сумын Үст хайрхан МБ, Есөн зүйл сумын Сарын гол, Баянхангай МБ-дэд нийт 3 худаг шинээр гаргав. Эдгээр 3 МБ-ээс 2009 оны 12 сарын 22-ны байдлаар зөвхөн Баянхангай МБ төлбөл зохих 10%-ийн 94%-ийг төлсөн байна. Төсөл хэрэгжих эхний жилд судалгаа, бодлогын бичиг барим боловсруулах, МБ-ийг сонгон шалгаруулах, тэдэнд сургалт явуулахад гол үйл ажиллагаа чиглэгджээ. Цаашид худаг уст цэг гаргах, нэвтрүүлэх төвийг байгуулах, үйлчилгээг сайжруулахад анхаарлаа хандуулах нь зүйтэй. Төслийн 2009 оны хэрэгжилтэд 72,0% буюу “шаардлага хангаж байгаа” үнэлгээг өгч байна.</p>
	Хөтөлбөр хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талууд боллоцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна.
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	<ol style="list-style-type: none"> 1.Шинээр болон сэргээн засварлах худгийн ажлын чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах. 2.МБ-ийг сонгон шалгаруулах ажлыг түргэтгэх. 3.Малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд төслөөс явуулж буй бизнес сургалтуудыг үргэлжлүүлэх. 4.Хөтөлбөр хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулж ажиллах шаардлагатай байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА